


Бизнесээ өргөжүүлэх гэж байна уу?

Турилагаас нь суралцаарай

Европын Холбоо ба ЕСБХБ-ны Хувь Нийлүүлсэн Тусгай Сангийн санхүүжилтээр интерьер, экстерьер дизайн, барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Рэндер компанид удирдлагын үр ашигийг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадвараа сайжруулахад нь тусалсан юм.



Интерьер, экстерьер дизайн Монгол улс

Бидний дэмжлэгээр Рэндер ХХК богино ба урт хугацааны зорилго тодорхойлж, бизнесийн үйл явцаа шинэчлэн загварчилсанаар байгууллагын бүтэц нь оновчтой болж, жилийн борлуулалтаа 313%, ажиллагсадын тоо 133%, бүтээмжээ 90%-иар нэмэгдүүлж чадсан юм.

Хүрэлбаатарын Эрдэмбилэг нь 1995 онд тавилгын үйлдвэрт дагалдан ажилтнаар ажил мэргэжлийн гараагаа эхэлжээ. Тэр агуулахад хураалттай, загвар нь хуучирсан ширээнүүдийг шинэ болгож харагдуулахын тулд будаж янзлах санаа олжээ. Ингээд будсан загвар нь компанийн удирдлагуудад таалагдаж, тус компанид ажилд орох саналыг хүлээн авч байжээ. Улмаар Эрдэмбилэг “Шилдэг Зохион Бүтээгч” болж шагнуулан будагчнаас загвар зохион бүтээгчийн ажилд дэвшин ажиллажээ. 1998 онд Х. Эрдэмбилэг нь Германд амьдардаг ах дүү нарынхаа дэмжлэгтэйгээр өөрийн хувийн тавилга үйлдвэрлэх цехээ нээсэн нь одоогийн Рэндер ХХК-ийн үүсэн байгуулагдах эх суурь тавигдсан байна.

Өнөөдөр тус компани зах зээлд сайн танигдсан ба бизнес нь тавилгын үйлдвэрлэлээс интерьер, экстерьер дизайн, барилга угсралтын компани боллоо өргөжин тэлсэн байна.

Тус компанийн дэлхийд алдартай Биессэ



фирмийн Компьютерийн Тоон Хяналт (CNC)-ын робот машин зэрэг орчин үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон тавилгын үйлдвэрт 70 гаруй ажилтан ажилладагаас 40 орчим хувь нь инженер болон загвар зохион бүтээгч нар байдаг байна.

Рэндер ХХК-ийн удирдлага худалдан авагчдын хэрэгцээг хангасан, өндөр чанар бүхий бүтээгдэхүүн, үйлчилгээ санал болгохын тулд компанийн бизнесийн өсөлтийн дүр зургийг илүү тодорхой, төлөвлөгөөн дээр үндэслэн хийх шаардлагатай гэдгийг ойлгож байлаа.

Бид Рэндер компанийг дотоодын зөвлөхүүдтэй холбож, стратеги болон бизнесийн процессуудаа шинээр загварчлан сайжруулах гэсэн 2 чиглэлээр зөвлөх үйлчилгээ авахад нь тусалсан юм.

Зөвлөхүүд :

- Компанийн урт болон богино хугацааны стратегийн зорилт, санхүүгийн төлөвлөлтийг тодорхойлсоноор илүү оновчтой шийдвэр гаргах, мөн төлөвлөлтөд суурилан бизнесийн гүйцэтгэлийг сайжруулах боломж олгосон.
- Удирдлагын болон бизнесийн процессуудыг шинээр загварчлан сайжруулж, дэмжих үйл явцуудтай нь цуг төлөвлөж, үйл явцын гарын авлагыг боловсруулсан

Оновчтой тодорхойлсон зорилт, ойлгомжтой компанийн бүтэц, зохион байгуулалттай мэдээлийн урсгал болон шинэ технологи хэрэгжсэнээр тус компанийн бүтэц, бизнесийн гүйцэтгэл сайжирсан байна.

Борлуулалтын орлого

+313%

Ажилчдын тоо

+133%

Бүтээмж

+90%

Нийт зөвлөх үйлчилгээний
төслийн өртөг

€16,300

Үйлчлүүлэгчээс гарсан

€8,400

www.ebrd.com/knowhow

